



Шүүхийн академийн Ёс зүйн дэд хорооноос
нийт албан хаагчдад зориулан
**“Төрийн албан хаагчийн хувцаслалтын
стандарт”**-ыг танилцуулж байна.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ



2.8. Байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд дараах хэм хэмжээг мөрдөнө.



2.8.2. харилцаа, хандлага, хувцаслалт, биеэ авч явах байдал, ажлын арга барил, үг, үйлдлээрээ бусдад зөв үлгэрлэн, манлайлах.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

MNS 7068:2025

7. Төрийн албан хаагчид тавих шаардлага



7.5.1 Төрийн албан хаагч нь ажлын байранд төлөв даруу, ажил хэрэгч, соёлтой, цэвэр, албаны төрхийг илтгэсэн хувцсыг өмсөнө.



7.5.2 Төрийн албан хаагчийн ажлын байранд өмсөх хувцас бусдыг өдөөсөн, тэдний анхаарлыг хэт татсан, хэт хээнцэр, элдэв этгээд загвар бүхий байж болохгүй.



7.5.3 Төрийн албан хаагч ажлын байранд өөрийн албан тушаал, нэр бүхий энгэрийн тэмдгийг хэрэглэж болно.





Шүүхийн академийн албан хаагчдад төрийн албан хаагчийн хувцаслалтын стандартыг баримталж, дараах зохисгүй хувцаслалт, хэв маягаас зайлсхийхийг зөвлөж байна.

Ажлын байран дээр ажлын цагаар спортын болон чөлөөт загварын, элдэв этгээд загвар бүхий хувцас, гутал өмсөхөөс зайлсхийх.



Ажлын байран дээр жийнс, савхи, гялгар материалаар хийсэн хувцас өмсөхөөс зайлсхийх.



Ажлын байран дээр хэт том, тод өнгийн болон олон тооны бөгж, ээмэг, зүүлт, бугуйвч зүүхээс зайлсхийх.



Албан хаагч нь үсээ этгээд байдлаар засуулахгүй, тод өнгөөр будахаас зайлсхийх.



Этгээд загвартай, тод өнгийн нарны шил болон тод өнгийн
контакт линз зүүхээс зайлсхийх.



**Албан хаагч ТА төрийн албан
хаагчийн хувцаслалтын
стандартыг баримтлан
ажиллахыг хүсье.**

Ёс зүйн дэд хороо